



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/240

Улаанбаатар хот

**Баянзүрх дүүргийн 55 дугаар
сургуулийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,825,782.15 /таван сая найман зуун хорин таван мянга долоон зуун наян хоёр төгрөг арван таван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн 55 дугаар сургууль /Ч.Ганбилэг/-д зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй 5,825,782.15 /таван сая найман зуун хорин таван мянга долоон зуун наян хоёр төгрөг арван таван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн 55 дугаар сургууль /Ч.Ганбилэг/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 07 сарын
 09 өдрийн А/АУО дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 55 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон жил	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Сурах бичиг	2011-2017	2-8 жил	ш	2,421	5,825,782.15	5,825,782.15			Сургалтын хөтөлбөрт хэрэглэгдэхгүй, урагдсан, э/ахуйн шаардлага хангахгүй	устгах
Номын фондын дүн					2,421	5,825,782.15	5,825,782.15	-	-		
Нийт дүн							5,825,782.15				
Актлах хөрөнгө							5,825,782.15				
Татан төвлөрүүлэх хөрөнгө							0.00				